



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: coo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	2
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага.....	
5.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.МӨНХБАТ
ТАНАА**

2022.08.25 № 118

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн “Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн “Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын 7 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2022 оны төлөвлөгөө нь 1,890,121.4 мянган төгрөг, гүйцэтгэл нь 1,883,647.5 мянган төгрөг 99,9 хувьтай байна. Улсын төсвөөс гүйцэтгэлээр 1,722,805.2 мянга, орон нутгийн төсвөөс 160,842.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,818,840.2 мянган төгрөгийг зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл

ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>46,636,167.93</u>	<u>61,883,222.65</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,820,937.78
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,820,937.78
3121	Төгрөг	-	10,820,937.78
31211	Төрийн сангийн харилцах	-	10,820,937.78
35	БАРАА МАТЕРИАЛ	46,636,167.93	51,062,284.87
351	Түүхий эд материал	16,035,080.43	15,685,880.43
35110	Тусгай зориулалттай материал	15,773,080.43	15,685,880.43
35130	Эм боох материал	262,000.00	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	14,000.00
354	Хангамжийн материал	23,004,087.50	28,452,404.44
35410	Бичиг хэргийн материал	542,000.00	592,600.00
35420	Аж ахуйн материал	5,216,100.00	8,234,750.00
35440	Түлш, шатах тослох материал	344,349.50	741,180.00
35450	Барилгын засварын материал	298,500.00	-
35460	Хүнсний материал	-	145,500.00
35470	Бусад хангамжийн материал	16,603,138.00	18,738,374.44
35600	Мал амьтад	7,597,000.00	6,910,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,806,875,458.79</u>	<u>1,825,692,952.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,806,875,458.79	1,825,692,952.20
392	Биет хөрөнгө	1,772,940,458.68	1,790,107,952.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,786,773,176.86	1,786,773,176.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(126,435,727.56)	(180,462,206.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,943,749.63)	(11,018,749.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,044,053.00	300,054,564.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(197,763,002.43)	(199,671,957.89)

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	146,105,518.57	124,278,924.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(107,923,137.12)	(94,983,216.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,632,300.00	15,632,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,115,291.89)	(9,691,711.93)
39217	Ном	33,066,318.88	37,696,829.88
393	Биет бус хөрөнгө	33,935,000.11	35,585,000.00
39301	Програм хангамж	800,000.00	2,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(774,999.89)	(575,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,910,000.00	33,910,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,853,511,626.72</u>	<u>1,887,576,174.85</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>6,128,496.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	6,128,496.00
413	Өглөг	-	6,128,496.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	6,128,496.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,853,511,626.72</u>	<u>1,881,447,678.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,853,511,626.72	1,881,447,678.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	498,583,809.63	498,583,809.63
51101	Өмч: - төрийн	498,583,809.63	498,583,809.63
512	Хуримтлагдсан үр дүн	(115,866,809.40)	(87,930,757.27)
51210	Өмнөх үеийн үр дүн	(546,252,893.12)	(1,969,378,436.12)
51220	Тайлант үеийн үр дүн	430,386,083.72	1,881,447,678.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,470,794,626.49	1,470,794,626.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,853,511,626.72</u>	<u>1,887,576,174.85</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,954,717,568.31	3,781,545,763.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	506,611,237.31	1,897,898,263.16
120	Нийтлэг татварын бус орлого	506,611,237.31	1,897,898,263.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	506,611,237.31	1,897,898,263.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,432,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,171,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	506,611,237.31	1,890,295,263.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,448,106,331.00	1,883,647,500.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,342,224,700.00	1,722,805,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,722,805,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,342,224,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,375,831.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,996,931.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,378,900.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,505,800.00	160,842,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,505,800.00	160,842,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,512,090,191.05	1,899,808,784.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,512,090,191.05	1,899,808,784.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,460,648,732.42	1,783,310,579.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,082,427,319.92	1,316,782,804.06
210101	Үндсэн цалин	772,670,468.57	910,200,923.14
210102	Нэмэгдэл	223,341,346.57	325,147,915.87
210104	Урамшуулал	86,415,504.78	81,433,965.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,177,600.00	163,089,538.52
210201	Тэтгэврийн даатгал	99,663,800.00	111,497,665.96
210202	Тэтгэмжийн даатгал	9,378,500.00	12,993,737.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,502,800.00	10,384,829.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,875,600.00	2,564,818.55
210205	Эрүүл мэндийн даатгал	18,756,900.00	25,648,486.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,473,892.95	80,366,211.61
210301	Гэрэл, цахилгаан	16,129,331.45	22,095,161.11
210302	Түлш, халаалт	53,686,811.50	54,791,050.50
210303	Цэвэр, бохир ус	2,657,750.00	3,480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,594,930.00	-
210401	Бичиг хэрэг	987,050.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,006,040.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,006,000.00	-
210404	Ном, хэвлэл	126,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,426,740.00	-
2105	Нормативт зардал	41,820,630.00	58,927,070.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	824,000.00	-
210502	Хоол, хүнс	39,975,330.00	58,927,070.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,021,300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,834,750.00	13,769,190.00
210604	Урсгал засвар	14,834,750.00	13,769,190.00
2107	Томилолт, зочны зардал	599,400.00	-
210702	Дотоод албан томилолт	599,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,872,950.00	15,684,189.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,872,950.00	5,432,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,252,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,847,259.55	134,691,576.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,001,300.00	40,412,697.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,277,700.00	18,743,892.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,568,259.55	75,534,987.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,441,458.63	116,498,204.53

2132	Бусад урсгал шилжүүлэг	51,410,388.00	115,369,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,618,218.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,792,170.00	115,369,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	117.55	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117.55	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,953.08	1,129,204.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,953.08	1,129,204.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	442,627,377.26	1,881,736,978.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,241,293.54	289,299.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,241,293.54	289,299.95
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(12,241,293.54)	(289,299.95)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	430,386,083.72	1,881,447,678.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,448,106,331.00	1,891,250,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,603,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	7,603,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,603,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,432,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,171,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,448,106,331.00	1,883,647,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,342,224,700.00	1,722,805,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,722,805,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,342,224,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,375,831.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,996,931.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,378,900.00	-
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,505,800.00	160,842,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,505,800.00	160,842,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,444,926,731.00	1,818,840,181.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,444,926,731.00	1,818,840,181.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,393,332,472.37	1,702,327,976.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,082,427,319.92	1,316,782,804.06
210101	Үндсэн цалин	772,670,468.57	910,200,923.14
210102	Нэмэгдэл	223,341,346.57	325,147,915.87
210104	Урамшуулал	86,415,504.78	81,433,965.05

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,177,600.00	163,089,538.52
210201	Тэтгэврийн даатгал	99,663,800.00	111,497,665.96
210202	Тэтгэмжийн даатгал	9,378,500.00	12,993,737.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,502,800.00	10,384,829.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,875,600.00	2,564,818.55
210205	Эрүүл мэндийн даатгал	18,756,900.00	25,648,486.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,505,692.45	80,728,296.11
210301	Гэрэл, цахилгаан	16,129,331.45	22,095,161.11
210302	Түлш, халаалт	53,618,611.00	55,153,135.00
210303	Цэвэр, бохир ус	2,757,750.00	3,480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,105,000.00	-
210401	Бичиг хэрэг	1,268,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,006,000.00	-
210404	Ном, хэвлэл	129,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	362,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,338,900.00	-
2105	Нормативт зардал	42,116,380.00	59,072,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	603,300.00	-
210502	Хоол, хүнс	39,944,580.00	59,072,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,568,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,999,990.00	13,499,990.00
210604	Урсгал засвар	14,999,990.00	13,499,990.00
2107	Томилолт, зочны зардал	599,400.00	-
210702	Дотоод албан томилолт	599,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,003,900.00	15,684,189.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,003,900.00	5,432,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,252,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,397,190.00	53,470,589.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	35,172,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,397,190.00	18,298,449.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,594,258.63	116,512,204.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,563,188.00	115,383,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,771,018.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,792,170.00	115,383,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	117.55	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117.55	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,953.08	1,129,204.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,953.08	1,129,204.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,179,600.00	72,410,318.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,179,600.00	61,589,381.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,179,600.00	61,589,381.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,179,600.00	61,589,381.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,179,600.00	61,589,381.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,179,600.00)	(61,589,381.00)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	10,820,937.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,820,937.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-115,866,809.40	1,853,511,626.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-115,866,809.40	1,853,511,626.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-115,866,809.40	1,853,511,626.72
D01	2012 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-115,866,809.40	1,853,511,626.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,853,511,626.72	-1,853,511,626.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-1,969,378,436.12	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,881,447,678.85	1,881,447,678.85
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	498,583,809.63	1,470,794,626.49	-87,930,757.27	1,881,447,678.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,890,121,400.00	1,879,300,357.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,890,121,400.00	1,879,300,357.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,774,738,400.00	1,763,917,357.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,324,971,000.00	1,316,782,804.06
210101	Үндсэн цалин	991,805,800.00	910,200,923.14
210102	Нэмэгдэл	281,354,300.00	325,147,915.87
210104	Урамшуулал	51,810,900.00	81,433,965.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,716,100.00	163,089,538.52
210201	Тэтгэврийн даатгал	112,694,200.00	111,497,665.96
210202	Тэтгэмжийн даатгал	13,258,100.00	12,993,737.56

210203	ҮОМШӨ-ний даатгал	10,606,500.00	10,384,829.75
210204	Ажилгүйдлийн даатгал	2,650,600.00	2,564,818.55
210205	Эрүүл мэндийн даатгал	26,506,700.00	25,648,486.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,728,300.00	80,728,296.11
210301	Гэрэл, цахилгаан	16,820,600.00	22,095,161.11
210302	Түлш, халаалт	61,423,900.00	55,153,135.00
210303	Цэвэр, бохир ус	2,483,800.00	3,480,000.00
2105	Нормативт зардал	59,072,600.00	59,072,570.00
210502	Хоол, хүнс	59,072,600.00	59,072,570.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,500,000.00	13,499,990.00
210604	Урсгал засвар	13,500,000.00	13,499,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,639,100.00	17,634,189.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,432,000.00	5,432,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,207,100.00	12,202,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,111,300.00	113,109,970.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,800,600.00	94,799,521.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,310,700.00	18,310,449.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,383,000.00	115,383,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,383,000.00	115,383,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	115,383,000.00	115,383,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,882,518,400.00	1,885,818,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,882,518,400.00	1,885,818,500.00
122005	Орон нутгийн төсвөөс	1,882,518,400.00	1,885,818,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,950,142.31

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль ” Хүүхэд бүрийн хөгжлийн төлөө хамтдаа-хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж , ая тухтай чөлөөт орчинд эрдэм мэдлэгтэй , эрүүл чийрэг , эерэг хандлагатай , эх оронч сэтгэлгээтэй ирээдүйн монгол хүнийг бүтээхэд оршино.” гэсэн зорилгын хүрээнд мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн

төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2023 оын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудиторгүй/ шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,064.5 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10,820.9	-10,820.9
Бараа материал	46,636.2	51,062.3	4,426.1
Үндсэн хөрөнгө	1,806,875.5	1,825,692.9	18,817.5
Нийт хөрөнгө	1,853,511.6	1,887,576.2	34,064.5
Өр төлбөр		6,128.5	-6,128.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	498,583.8	498,583.8	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,853,511.6	1,887,576.2	34,064.5

Мөнгөн хөрөнгө 10,820.9 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,826,828.2 мянган төгрөг буюу 93 хувиар өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн. Мөн бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоотоор “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах” чиглэлийн дагуу өөрчлөлтүүд орсон байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 387,718.6 мянган төгрөг буюу 25.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, байр ашиглалттай холбоотой тогтмол, бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 234,355.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 7,892.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 44,844.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсвийн байгууллагаас тус байгууллагын 2022 оны төсвийг 1,722,805.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,722,805.2, орон нутгийн төсвөөс 160,842.3, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 7,603.0 мянга нийт 1,891,250.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,818,840.2 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн 10,820.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, хөрөнгө худалдан авахад 61,589.4 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 1,129.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна..

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	81834-Боловсролын стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээ	1,216,011.50	1,215,116.90	894.6	99.93%
2	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээ	230,847.00	221,011.40	9,835.6	95.74%
3	81806-Дотуур байрын үйлчилгээ:	76,697.74	76,608.00	89.74	99.88%
4	81801-Үдийн цай хөтөлбөр	115,383.00	115,383.00	0	100.00%
5	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	4,882.90	4,882.90	0	100.00%
6	80312-сургалт семинар	2,441.40	2,440.40	0.9	99.96%
7	81605-Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	5,615.30	5,615.20	0.1	100.00%
8	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	59,940.00	59,940.00	0	100.00%
9	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	10,986.40	10,986.40	0	100.00%
	НИЙТ	1,722,805.2	1,711,984.2	10,821.0	99.37%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй, үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон 7,603.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд БЧШ-5 төслийн хүрээнд бага ангийн сурагчдын хоцрогдлыг арилгах чиглэлээр бичиж зөв бичиг, уншлага, өгүүлбэртэй бодлого бодох үйл ажиллагааг жилийн туршид анги нийтийн массаар нь үр дүнтэй хэрэгжүүлж Боловсролын ерөнхий газрын мониторингд сайн үнэлүүлж, өгүүлбэртэй бодлого бодох арга зүйгээ улсын сайн туршлагад бүртгүүлсэн. Дунд ангийн сурагчдын дунд ESEL төслийг хэрэгжүүлж тус сургуулиас 8 төсөл санхүүжилт авахаар шалгарсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор С.Энхтөр гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, хяналтыг Сүхбаатар аймаг дахь аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 20 -ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 15,120.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,584.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.11, 15.2.32-т зардлыг хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд түлш, халаалтын зардал 1,104.2 мянган төгрөг, гэрэл, цахилгааны зардал 5,965.8 мянган төгрөг, цэвэр болхир усны зардал 822.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түлш халаалтын зардал:* Эдгээр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд өмнөх оноос дунжаар 10.9 хувиар нэмэгдсэн нь 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1.-д “...тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ерөнхий боловсролын сургуульд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 1,444,804.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 503,209.8 мянган төгрөгийн залруулга хийж, 1,511.8 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож, 10,721.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 929,361.5 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж авсан байна. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг 100% биелүүлсэн байна.

Хүснэгт 3 .Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Залруулга	1	503,209.8	1	503,209.8	100%
Төлбөрийн акт	1	1,511.8	1	1,511.8	100%
Албан шаардлага	1	10,721.2	1	10,721.2	100%
Зөвлөмж	2	929,361.5	2	929,361.5	100%
Нийт дүн	5	1,444,804.3	5	1,444,804.3	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,607.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн буюу 37,607.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нэг зөвлөмж хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Аж ажуй нэгж байгууллагатай холбоотой 37,607.2 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтыг бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар мөрдөж байгууллагын НБББББ стандартын дагуу бүртгэлд тусгах.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2022 онд нийт 149 мэдээллийг ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэн стандартыг тогтоох журам”, -тай нийцэхгүй байна.

